МАНАЙ СОНИНЫ III УЛИРЛЫН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,091,811... УСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.07.01. Баасан. №132 (4502) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

УРАН БҮТЭЭЛЧ



# Л.РЕНЧИННЯМ:

## ДАРХАД ДУУГ ПОП ОПЕРА УРСГАЛД ОРУУЛЖ ДУУЛАХ НЬ МИНИЙ МӨРӨӨДӨЛ

Дэлгэрэнгүй ярилцлагыг IV-V нүүрнээс

ДЭЛХИЙ

ДЭВИД КАМЕРОНЫГ ХЭН ЗАЛГАМЖЛАХ ВЭ

VI нүүрт

ШУУРХАЙ МЭДЭЭ

ПРОТЕЗИЙН ХЭРЭГСЛИЙГ ГАДААДАД ХИЙЛГЭЖ БОЛНО

VII нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

# АН-д намаа шинэчлэх даалгавар, МАН-д ахиад нэг боломж өгсөн СОНГОЛТ БАЙЛАА

Б.ӨНӨРТОГТОХ

Монголчууд төрийн эрх барих улс төрийн намаа сонголоо. Олонхийг бүрдүүлэх эрхийг нэг л намд өглөө. Олон намын төлөөлөл багтсан алаг эрээн сонголтыг энэ удаад хийсэнгүй. Намыг биш хүнийг нь харж өгнө гэсэн явуургүй улс төр ч энэ удаад болсонгүй. Монголчууд эв нэгдэл, тогтвортой байдлыг илүүд үзжээ. Нөгөө талаар өнөөдрийн амьдралынхаа ламжтай байвал, маргаашийн ирээдүй тийм ч чухал биш гэсэн сонголт хийчихлээ. Өчигдөр 09:00 цагт СЕХ-ноос өгсөн эцсийн мэдээллээр Монгол Улсын хэмжээнд УИХ-ын 76 суудлын 65-ыг МАН-ынхан авч үнэмлэхүй ялалт байгуулжээ. Өөрөөр хэлбэл, тэд дангаараа УИХ, Засгийн газраа бүрдүүлэх эрхтэй болов. Харин өнгөрөгч дөрвөн жилд олонхи бүрдүүлэх эрхийг л авч, МАХН, МАН-тай засаг байгуулж үзсэн АН-ынхан ялагдал хүлээж, дөнгөж бүлэг байгуулах хэмжээнд буюу есөн гишүүнтэй болов. Мөн МАХН-аас О.Баасанхүү, бие даагч С.Жавхлан нар төрийн төлөөлөл болж, парламентын танхимд суух эрхээ авлаа. Шинэ парламентын гишүүд өнөөдөр СЕХ-ноос түр үнэмлэхээ гардан авах юм.

Үргэлжлэл нь III нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




Дугаарын 60 мөр

# Гол уснаас болгоомжлоорой

Э.ТУУЛ

Монгол түмэн зургадугаар сарын турш сонгуулиар амьсгалж, саналаа өгснөөр нэг юм амсхийв. Гэтэл 10-хан хоногийн дараа монгол түмний их баяр цэнгэл, дэлхийд ганцхан дэнж хотойлгосон наадам айсуй. Түүнчлэн наадамтай залгуулаад буюу энэ сарын 14, 15-нд АСЕМ-ын Дээд түвшний XI уулзалт зохион байгуулагдана. Хүмүүс ч их ажлын ард гарсан, бас АСЕМ-ын үеэр хотод байлгахгүй гэсэн болохоор амарч, зугаалах нь тодорхой болж, зарим нь ч аль хэдийнэ майхан саваа бэлдээд эхэлчихэж. Манайхан сурсан зангаараа голын эрэг дээр очиж, хөдөө гарч амрах нь тодорхой. Нэгэнт нийслэлд байж болохгүй юм чинь ингэхээс ч яах вэ. Угаасаа л манайхан хэзээний амралтын өдрөө ая тухтай өнгөрүүлж, зугаалж, наргих дуртай хүмүүс. Бүр гэр бүл, найз нөхдөөрөө нийлж аваад л, хээр гарч, гол усанд тоглоно. Ингэж амарч, зугаалах нь мэдээжийн хэрэг сайхан.

Үргэлжлэл нь III нүүрт




ТАЛАРХЛЫН ҮГ

*Эрхэм хүндэт Хөвсгөлчүүд ээ,*
*Ахан дүүс ээ,*



Та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Монгол эх орны маань хоймор сайхан нутаг-Хөвсгөл аймагтаа Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшин өрсөлдөө. Үзсгэлэнт далай ээжийгээ нар зөв тойрон иргэд, сонгогчидтойгоо уулзаж, тэдний амжилт бүтээл, бэрхшээл хүндрэлийг сонсож, АН-ын мөрийн хөтөлбөрийг танилцуулаа. Олон хүн итгэл, найдварын очтой харцаар харж, дэмжиж байсныг их мэдэрсэн. Гэвч Та бүхнийхээ итгэл найдварыг биелүүлэхийн төлөө ажиллах боломж олдсонгүй.

Ардчиллын амин сүнс нь хүний эрх, эрх чөлөө, чөлөөт сонголт билээ. Бид төрийг төвхнүүлэх их үйлсийн төлөө бодлогоор өрсөлдөх хэрэгтэй. Бэлэг дурсгал, мөнгө төгрөг, "цаҳааны нүүдэл", албан тушаалтны сүлжээгээр сонгогчдын саналыг урвуулах явдал үгүй төгсөнө гэдэгт итгэнэм.

Хөвсгөл хөгжиж, хөвсгөлчүүд сайхан амьдрах эрхтэй. Монголын минь ирээдүй гэгээн байх болтугай.

**Хүндэтгэсэн**

**УИХ-ын 37-р тойрогт АН-аас нэр дэвшсэн**
**Пунцагийн ЦАГААН**

**2016 оны 6 дугаар сарын 30-ны өдөр**

**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1978.00 | 1998.00 | ФУНТ | 2609.00 | 2701.00 |
| ЕВРО | 2175.00 | 2237.00 | РУБЛЬ | 29.10 | 33.30 |
| ИЕН | 19.04 | 19.61 | ЮАНЬ | 294.00 | 301.50 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1977.00 | 1998.00 | ФУНТ | 2620.00 | 2710.00 |
| ЕВРО | 2171.00 | 2245.00 | РУБЛЬ | 29.90 | 33.00 |
| ИЕН | 18.99 | 19.70 | ЮАНЬ | 295.30 | 301.40 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## Э.БАТ-ҮҮЛ: ДАРААГИЙН ЭРХ БАРИГЧДАД ЗАХИХ ГУРВАН ЗҮЙЛ БАЙНА



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ж.ОТГОН

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Э.Бат-Үүл мэдээлэл хийлээ. Тэрбээр хурлын эхэнд "НИТХ-ын сонгуулийн дүн гарч нийслэлийн Ардчилсан нам 11 суудал, МАН үнэмлэхүй ялалт байгуулжээ. Юуны өмнө Нийслэлийн сонгуулийн хороо маш зохион байгуулалттай ажилласанд талархал илэрхийлж байна. Дараа нь биднийг дэмжсэн сонгогчиддоо талархаж байна. Өнгөрсөн дөрвөн жилд нийслэл ид шидтэй мэт бүтээн байгуулалт хийхэд дэмжиж оролцсон нийт иргэддээ талархаж байна.

> ...Сонгуулийн үр дүн нийслэлийн Ардчилсан намын хувьд улс төрийн "цунами" байлаа. Бид ялна гэдэгт итгэлтэй байсан ч иим үр дүн гарлаа. Сонгуулийн дүн гарсны дараа мэдэмхийрдэг мэргэн түргэн хүн олширдог. Гэхдээ энэ сонгуулиар бүтээн байгуулалтаас илүүг харлуулсан хүнийг олон түмэн дэмжлээ...

Нийслэлийн амьдрал өөр болсон гэдэгт санал нэгтэй байгаа байх. Иргэдийн зүгээс дараа дараагийн хотын удирдлагуудад тавих шаардлага өндөр болсон байх гэж найдаж байна. Сонгуулийн үр дүн нийслэлийн Ардчилсан намын хувьд улс төрийн "цунами" байлаа. Бид ялна гэдэгт итгэлтэй байсан ч иим үр дүн гарлаа. Сонгуулийн дүн гарсны дараа мэдэмхийрдэг мэргэн түргэн хүн олширдог. Гэхдээ энэ сонгуулиар бүтээн байгуулалтаас илүү харлуулсан хүнийг олон түмэн дэмжлээ. Утга учиргүй хүнийг гүжирдэж, харлуулах замаар сонгуульд амжилт олж болдог гэдгийг харууллаа" гээд нийслэлийн МАН-ынхан НИТХ-д үнэмлэхүй ялалт байгуулсан үр дүнг хүлээн зөвшөөрч, "МАН-аас бор халзан хонь ч сонгогдохоор иим сонгууль болсон" гэсэн юм. Мөн тэрбээр "Ард түмэн бүтээн байгуулалтын ажлаас илүү хар гүтгэлгэд итгэлээ. Улс төрд иим хандлага тогтчихлоо. Өнгөрсөн дөрвөн жилд нийслэлд бүтээн байгуулалтын олон ажил өрнөсөн. Дараагийн эрх баригчдад захих гурван зүйл байна" хэмээсэн юм.

Тэрбээр Нэгдүгээрт, Гэр хорооллын дахин төлөвлөлт буюу "Сайн хашаа" хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Хашааны газар дээр тохилог орон сууц барих замаар Улаанбаатарын утаа, эдийн засгийн хямралаас гарах өөр арга зам байхгүй. Тийм учраас эрх баригчид үүнийг ойлгож, бидний эхлүүлсэн "Сайн хашаа" хөтөлбөрийг үргэлжлүүлэх хэрэгтэй.

Хоёрдугаарт, "Төрийн үйлчилгээний супер маркет" эхлүүлсэн. Энэ нь дарга нарын ширээний дор нуудаг эрх мэдлийг төрийн үйлчилгээний супер маркетын лангуун дээр тавьж, ард иргэддээ үйлчилдэг засаг захиргаа бий болгох ажил эрчимтэй эхэлсэн. Өнөөдрийн байдлаар 400 мянган хүн үйлчилгээ авсан байдаг. Ер нь ард иргэдээ далайлгаж, дарамталсан, дарга нарын захиргааг бий болгож болохгүй. Манай нийслэлийн ард иргэд төрийн үйлчилгээг хүртэж, эрх чөлөөтэй амьдрах эрхтэй хүмүүс шүү.

Гуравдугаарт, "Найрсаг Улаанбаатар хөтөлбөр"-ийг гацааж, зогсоож болохгүй. Энэ хөтөлбөр бол нийслэлийн соёл урлагт бодитой дэмжлэг үзүүлсэн юм. Гэтэл зогсчихвол харамсалтай. Нэн ялангуяа Даншиг наадмыг улстөржүүлж зогсоож болохгүй. Даншиг наадам эхэлж байхад ардын хувьсгалын наадамтай өрсөлдүүлж иим юм хийж байна гэх буруу ташаа ойлголт төрүүлэхээр мессэж цацагдаж байсан. Бизориудхэлмээрбайна, тийм санаа бодол байгаагүй. Ер нь "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн хүрээнд аялал жуулчлалыг татах боломж нэмэгдсэн юм шүү. Мэдээж хэрэг газрын наймаа, авлигал зогссон. Нэгэнт эхлүүлсэн бүтээн байгуулалтын ажлыг сааруулж болохгүй. Та бүхний итгэл найдварыг хугалалгүй дөрвөн жил ажилласан гэдгээ бардам хэлнэ Нийслэлчүүддээ баярлалаа" гэлээ.

Энэ үеэр тэрбээр "МАН НИТХ болон УИХ хуралд олонхийг авлаа. Энэ ард түмний сонголт байлаа" гэдгийг онцолж, нийслэлийн намын даргын хувьд намын хурлаа хуралдуулаад намын даргаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ тавина гэдгээ мэдэгдлээ.


mminfo.mn Шударга, Шуурхай, Өнгөй мэдээлэл

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.


МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Ц.Сандуй: Өмнөх удирдлагуудын ажлыг үргэлжлүүлнэ

Нийслэлийн МАН-ын хорооноос өчигдөр мэдээлэл хийлээ. Энэ үеэр Нийслэлийн МАН-ын хорооны дарга Ц.Сандуй "Нийслэлийн ИТХ-ын сонгуульд МАН 45 суудлаас 34-ийг нь авч яллаа. Салбар, салбарын тэргүүний шижигнэсэн залуусыг нэр дэвшүүлсэн. Бидэнд итгэл хүлээлгэсэн нийслэлчүүддээ баярлалаа. 2016 оны НИТХ-ын сонгуульд МАН хүнээ дээдэлсэн үзэл, аз жаргалтай хот мөрийн хөтөлбөр дэвшүүлсэн. Энэ удаагийн сонгууль их сургамжтай боллоо. Сонгогчид дөрвөн жилийн өмнө амласан амлалтыг нь эрх баригчдаас нэхлээ. Биелэлтийг нь шалгалаа. Тиймээс бид ирэх дөрвөн жилийн хугацаанд дэвшүүлсэн мөрийн хөтөлбөрөө бүрэн хэрэгжүүлнэ. Нийслэлчүүддээ тухай бүрт нь ажлаа тайлагнана. Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд эрх барьсан удирдлагуудын бодлого, үйл хэргийг үргэлжлүүлнэ" хэмээсэн юм.

## Өнөөдөр УИХ-ын гишүүдэд түр үнэмлэх олгоно

Энэ удаагийн сонгуульд нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын 72.1 хувь нь саналаа өгсөн тул хуулийн хүрээнд хүчин төгөлдөр болсон билээ. Сонгуулийн тухай хуульд зааснаар Сонгуулийн ерөнхий хороо Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдогчдын нэрсийн жагсаалтыг сонгууль дууссанаас хойш 15 хоногийн дотор гаргаж, Монгол Улсын Ерөнхийлөгчид айлтган нийтэд мэдээлдэг. Түүнчлэн СЕХ урьдчилсан дүнг хэлэлцэх бөгөөд сонгогдсон гишүүдийг танилцуулах, сонгогдсон гишүүдэд түр үнэмлэх олгох асуудлыг хуралдаж, шийддэг учиртай.

Тэгвэл хурлын шийдвэр аль хэдийнэ гарсан байна. Тодруулбал, өнөөдөр СЕХ-ны байранд 12:40 цагт УИХ-ын гишүүний түр үнэмлэх олгох тов гарчээ.

ШАР МЭДЭЭ

## Баабар: Энэ сонгуулийн дүнд би баярлаад үхэх нь

УИХ болон аймаг, нийслэлийн ИТХ-ын ээлжит сонгуулийн үр дүнд олон хүн эргэлзэж тээнэгэлзэж буй. Орон даяар явагдсан ээлжит сонгуулийн дүнд өнгөрсөн дөрвөн жил төрийн эрх барьсан АН-ынхан дөнгөж бүлэг бүрдүүлэх хэмжээний буюу есөн суудал авч, харин Ардын нам үнэмлэхүй олонхи буюу 65 суудал, бие даагч нэг, МАХН-аас нэг гишүүнтэй болсон юм. Мөн НИТХ-д ч МАН 34 суудал авч, АН 11 суудал авсан билээ. Санаанд оромгүй дүн тавиулж орхисон АН-ынхны хувьд ялагдлаа хүлээн зөвшөөрсөн. Тэгвэл АН-ын ялагдлын шалтгааныг олон нийт тал талын өнцгөөс шүүж буй. АН-ын ахмад гишүүдийн нэг нийтлэлч Баабар АН-ын ялагдлын талаар жиргэсэн нь цахим орчинд анхаарал татаж байна. Тэрбээр, "Монголын ард түмнийг Зи, Фортуна хоёроос салгаж өгсөн Монголын ард түмэндээ баярлалаа. Би АН-д хайртай. Гэхдээ энэ сонгуульд ялагдаасай гэж өдөр болгон бурхандаа мөргөдөг байсан. Яагаад гэвэл, Зи-ээс салаасай гэж. Х.Тэмүүжин минь одоо намыг шинэчлэх, луйварчдаас салгах цаг нь ирсэн. Сонгуулийн үр дүнд би баярлаад үхэх нь. Энэ сонгуульд МАН хохирно. АН-аас болсон гэж нэг жил ярина. Үг дуусна. АН луйварчдаасаа сална. Зи үхнэ. Хиншүү Ганбаа, Уянгыг сонгодоггүй миний ард түмэн ухаан дорой ч мэргэн шүү. Ард түмэндээ баяр хүргэе. МАН одоо бохирын үүр болно. Манай АН мандана" хэмээн жиргэжээ.

## Шинэ УИХ-ын анхны хуралдааныг Ч.Улаан даргалах гэнэ

Парламентын шинэ гишүүд тангаргаа өргөснөөр өмнөх парламентын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болно. УИХ-ын чуулганы Дэгийн тухай хуулиар шинэ парламентын эхний хуралдааныг гишүүдийн хамгийн ахмад настай нь даргалах ёстой. Тодруулбал, тус хуулийн 11.2-т "Шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн тангараг өргөх ёслол үйлдэж, Улсын Их Хурлын даргыг сонготол чуулганд оролцсон гишүүдийн насаар хамгийн ахмад гишүүн чуулганы хуралдааныг зохион байгуулж даргална" гэж заасан юм. Тэгвэл энэ удаагийн парламентын гишүүдийн хамгийн ахмад нь УИХ-ын гишүүн Ч.Улаан юм байна. Тэрбээр 1954 онд төрсөн бөгөөд 1996 оноос хойш УИХ-ын гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа.

Түүнчлэн гурван ч удаа Сангийн сайдаар ажиллаж байсан юм. Тодруулбал, 2000-2004 онд Засгийн газрын гишүүн, Сангийн сайд, 2007-2008 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд, 2012-2013 онд Засгийн газрын гишүүн Сангийн сайд, 2004-2006 онд Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайдаар ажиллаж байсан билээ.

МЭДЭЭЛЭЛ

## ХАМГИЙН ТОМ АЛДАА СОНГУУЛИЙН СИСТЕМ БАЙЛАА ГЭВ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ж.МЯГМАР

"Тусгаар тогтнол эв нэгдэл" /ТТЭН/ эвслээс УИХ, аймаг, нийслэлийн сонгуулийн үр дүнгийн талаар байр сууриа илэрхийлэв. Энэ талаар ТТЭНН-ын дарга, УИХ-ын гишүүн Г.Уянга "Ард түмнийхээ сонголтыг хүндэтгэж, үнэмлэхүй олон суудал авсан МАН-д баяр хүргэх нь зүйтэй. Гэхдээ амаргүй он жилүүд эхэлж байна. 2017 оноос Монгол Улс төсвийнхөө талыг өр зээлийн төлбөр, хүүнд төлж эхэлнэ. Үнэнийг хэлэхэд, энэ ялалт МАН сайн байсанд бус өөр хэд хэдэн хүчин зүйл нөлөөлсөн. Хамгийн том алдаа бол сонгуулийн систем байлаа. Жижиг мажоритар системийн үед сонгуулийн санал хамгийн ихээр гээгддэг. Намуудад өгсөн саналыг хувилж үзвэл гээгдсэн нь ил болно. Сонгогчдын саналын гуравны нэг нь гээгдсэн. Үүнээс гадна бусад нам эвслүүд нэгдмэл байж чадаагүй, цул хүчин МАН-ын эсрэг тархай бутархай байлаа. Өмнөх мажоритар сонгуулийн үр дүн ч иим гарсан" гэлээ. Мөн тэрбээр "ТТЭН эвсэл бол 26 жилийн дараа ард түмэнд өөр сонголт бий болгож гарч ирсэн. Бид маш амжилттай оролцсон. Манай эвслээс УИХ-д 44 суудалд, НИТХ-д 29 суудалд нэр дэвшсэн. УИХ дахь нэр дэвшигчдийн авсан санал улсын хэмжээнд 35600 болж нам, эвслүүдийн авсан тоогоор дөрөвдүгээрт эрэмбэлэгдэж байна. ТТЭНН нэг жилийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлж, хоёр сарын өмнөөс шинэчлэгдсэн эвсэл болж сонгуульд орсон. Хоёр сарын хугацаан дахь бидний үр дүн дөрөвт эрэмбэлэгдэж байгаад ТТЭН эвслийн өмнөөс ард түмэндээ баярлалаа гэж хэлэх ёстой. Ямар ч улс төрийн хүчин байгуулагдаад хоёр сарын хугацаанд иим өндөр амжилт үзүүлж байгаагүй. Тиймээс бид цаашдаа энэ амжилтаа бататгаж, улам хичээж зүтгэн ажиллаж, улс төрийн тэргүүлэгч хүчин болохоор зүтгэнэ. Үүний төлөө зөв хүмүүстэй эвлэлдэн нэгдэж, нэгдмэл хүчтэй болно. МАН хэдийгээр олонхи болж байгаа ч улсад нүүрлэсэн засаглалын хямралыг шийдэж чадахгүй учир Үндсэн хуулийн өөрчлөлтийг зайлшгүй хийх ёстой" гэв.

## ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын 60 мөр

### Гол усноас болгоомжлоорой

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Гэвч амарч зугаалахдаа анхаарал болгоомжгүй, архидан согтуурснаас үүдэн амиа ч алдах эрсдэл бийг санах хэрэгтэй. Саяхан нийслэлд хоёр хоног усархаг бороо орсны улмаас улсын хэмжээнд гол усанд 18 хүн эндсэн харамсалтай мэдээ гарсан. Мөн нийслэлийн хэмжээнд гурван хүн усанд осолдсон талаар онцгой байдлынхан хэлж байсан. Түүгээр ч барахгүй амралт зугаалганд явж байгаа иргэд гол усанд осолдож, амиа алдах, бэртэж гэмтэх тохиолдол долдугаар сард ихэсдэг гэнэ билээ. Тиймээс л иймхүү анхааруулж, сэрэмжлүүлээд байдаг хэрэг. Харин сануулж, сэрэмжлүүлээд байхад саваагүйтэж яваад гол усанд эндчих вэ дээ. Одоохоос онцгой байдлынхан сануулаад эхэлсэн шүү. Учир нь долдугаар сар тэр чигтээ бороо хуртай байна гэдгийг цаг уурын байгууллагаас сануулаад байгаа юм. Тодруулбал, "Долдугаар сард бороо орно. Ер нь баруун зүгийн зарим газраар дундаж хэмжээнээс багавтар, говийн бүсийн нутгаар дунджаас их, бусад нутгаар дундаж хэмжээнд хур тунадас бороо орох төлөвтэй байна. Температурын хувьд нутгийн баруун хагас, төвийн нутгийн зүүн хойд хэсгээр дунджаас дулаан, бусад нутгаар дундаж хэмжээний орчим байна. Одоогоор бороо яг хэзээ орохыг хэлэх боломжгүй. Гэхдээ долдугаар сард бороотой байна. Наймдугаар сард ч гэсэн бороо орох төлөвтэй байна. Ер нь өмнөх жилүүдээс харж байхад долдугаар сар бороотой, ялангуяа дуу цахилгаантай, усархаг аадар бороо ихтэй байдаг. Зуны гурван сарын хамгийн их бороотой нь долдугаар сар юм. Тиймээс ард иргэд үер, усны аюулаас анхаарал болгоомжтой байх хэрэгтэй" гэж албаны хүн нь анхааруулж байна билээ. Манайхан зургадугаар сар ч бороотой л байсан, юун сүртэй юм гээд хэнээгүй царайлж мэдэх л хүмүүс. Гэтэл дуу цахилгаантай, усархаг аадар бороо их орвол гол усны төвшин нэмэгдэж, үер ч буух магадлалтай. Ялангуяа манайхны их зорчдог баруун зүгийн аймгууд буюу Увс, Говь-Алтай, Ховд, Завхан, Баян-Өлгийн хойд хэсгээр бороо орно гээд байгаа. Цаг уурын байгууллагаас ирүүлсэн мэдээгээр Алтайн нуруунаас эхтэй Булган, Хар бут, Ховд, Хөвсгөлийн уулсаас эхтэй Богд, Завхан, Орхон, Улиастай, Хэнтийн нуруунаас эхтэй Сэлэнгэ мөрөн, Баянхонгор аймгийн Байдраг, Шаргалжуут гол Өвөрхангай аймгийн Онги голууд үерлэж, усны төвшин их хэмжээгээр нэмэгдэн аюултай байдалд хүрээд байгаа гэсэн. Тиймээс нийт иргэд, эцэг эхчүүд хүүхэддээ тавих хараа хяналтаа сайжруулж, хүүхдүүдээ гол усны эрэг дагуу явуулж, тоглуулахгүй байх, амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэхдээ гол усны ойролцоо амарч зугаалахгүй байх, цаг агаарын мэдээг тогтмол хүлээн авч, баталгаат зам гүүрээр зорчиж машинаар гол гатлахыг оролдохгүй байх, голын усны төвшин нэмэгдэн үед голд сэлэхгүй байхыг сэрэмжлүүлж байсан шүү. Хүний үг авахгүй, сэрэмжлүүлж сануулаад байхад тоохгүй гараад явчихдаг гэм манайханд бий. Өвлийн улиралд цас их орно битгий яваарай гэхээр л гарч яваад цасанд суугаад, өөрсдийнхөө ч, улсын ч хөрөнгийг бараад байдаг зантай. Тэгвэл энэ сард бороо их орно шүү гээд онцгой байдлынхан эртнээс сэрэмжлүүлээ шүү. Анхааралдаа авчихад гэмгүй л байх.

# АН-Д НАМАА ШИНЭЧЛЭХ ДААЛГАВАР, МАН-Д АХИАД НЭГ БОЛОМЖ ӨГСӨН СОНГОЛТ БАЙЛАА

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**


Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Ялалт, ялагдлыг нэг намд дангаар үгүүрүүлсэн энэ удаагийн сонголт олон талаар өвөрмөц байсан юм. Тодруулбал, УИХ-д өнөө жил ардчилсан сонгуулийн түүхэн дэх хамгийн олон эмэгтэй гишүүд суух гэж байна. АН-аас нэг эмэгтэй, харин эрх баригч МАН-аас 12 эмэгтэй улстөрч сонгогджээ. Түүнчлэн, МУГЖ нэг гишүүнтэй болсон бол үндэсний бөхийн хоёр дархан аварга, нэг аварга төрийн түшээтэй болов. Хамгийн залуу улстөрчөөр Хэнтий аймгаас нэр дэвшин сонгогдсон Д.Гантулга гэх залуу тодорлоо. Тэрбээр, 29 настай аж. Энэ мэтээр сонгуулийн онцлог, үр дүн, АН-ын ялагдал, Ардын намын ялалтын талаар хэвлэл мэдээлэл бүр өөр өөрийн өнцгөөр дүгнэн бичиж байна. "ММ" ч энэ удаагийн дугаарт МАН-ын ялалт, АН-ын ялагдлыг өөрсдийн өнцгөөр тоймлов.

### АН–ын ялагдал ард түмнээ хэт басч байсны үр дүн

Үнэмлэхүй ялалтын үр дүн яагаад ирсэн, өнгөрсөн дөрвөн жилд хамгийн их бүтээн байгуулалт хийсэн АН яагаад ялагдахад хүрэв гэдгийг хүмүүс олон янзаар тайлбарлаж буй. Гэхдээ сонгуулийн үр дүн хэний ч таамаглаж байгаагүй үр дүн байсан юм. Тэр тусмаа АН-ын хувьд, иим зүйл хүсээгүй. Олон удаагийн судалгаа рейтингээс харсан ч АН олонхи бүрдүүлж чадахгүй ч эвсэл байгуулах хэмжээнд суудал авах нь тодорхой байв. Гэвч яагаад, юуны учир шат шатны сонгуульд ялагдал хүлээв гэдгээ АН-ын бусдаас бус өөрсдөөсөө асуух хэрэгтэй болжээ. АН төрийн эрх барих дөрвөн жилийн хугацаандаа бүтээж босгож чадаг гэдгийг хангалттай харуулсан. Тэд хийж чадсан. Үүнийг хэн ч үгүйсгэхгүй. Хийсэн бүтээсэн нь нудний өмнө харагдаж, гарт баригдаж буй. Тэр тусмаа газрын наймаа, авлига, хүнд суртлын үүр уурхай болсон нийслэлийг Э.Бат-Үүл ба түүний нөхөд 360 градус өөрчилж чадлаа. Гэвч монголчууд бид хэтэрхий богино ой санамжтай юм. Өмнө ямар байснаа мартчихаж. Нөгөө талаар дэрээ хөлөө олохгүй бол дороо гүйдлээ олохгүй гэгчээр дээдсийн толхилцоон нийслэлийн шинэчлэлийг хүртэл хөлдөө чирсэн нь энэ юм. АН-ынхан нэг удаа Засгийн газраунагаав. Н.Алтанхуягийг тэд өөрсдөө улайрсаар унагаж байлаа. Өөрийнхөө хүнийг улдан татаж, орон шоронд оруулж байлаа, тэд. Журмын нөхрийнхөө ар нуруунаас хут-галж, жинхэнэ хэрүүл тэмцэл, үл ойлголцол, зөрчил толхил-цооныг өнгөрсөн дөрвөн жил харуулжээ. Тиймдээ ч ард түмэн АН-ын хийсэн ажлаас биш хэмлэлдээнээс залхсандаа л иим сонголт хийчихэв. Нөгөө талаар монголчууд мөнгөнд хууртахгүй гэдгээ харууллаа. АН-ынхан сонгуулийн өмнөхөн олон поп амлалт өгсөн. Хувьцаа-гаа 300 мянгаар худалдах, "Сайн оюутан", "Сайн малчин" гэх мэтээр олон ч популист амлалт өгч байв. Нэг ёсондоо мөнгө өгье, та бидэнд саналаа өгчих гэсэн утгатай мэдэгдэл ар араасаа хийж, ард иргэдийг басч байлаа. Гэвч монголчууд өмнөх шигээ улстөрчийн атгуулсан хэдэн халтар төгрөг, поп амлалтад хууртахгүй болжээ. Энэ ч сайн жишиг болж, улс төрийн бусад намуудад сургамж болсон нь дамжиггүй.

> ...Харин илүү их хариуцлагатай, эв нэгдэлтэй, дотоод зөрчил биш улс эх орны хөгжлийн төлөө л цаг наргүй ажиллах шаардлагатай болж байна. Өмнөх хийснийг баллуурдаж, эрх барьж байсан нэгнээ үгүйсгэдэг, өш хонзонгийн сэдэлтэй улс төр хийхийг ард түмэн тэвчихгүй. Улстөржилт бус улс орны хөгжлийн төлөө хоёргүй сэтгэлээр ажиллаж чадахгүй л бол МАН дахиад хэн ч биш болно...




### Хэвлэл мэдээллийг үл тоож болохгүйг харууллаа

АН-ын ялагдлын бас нэгэн шалтгаан бол хэвлэлийн пиараа буруу хийсэн явдал гэдгийг олон ч судлаачид хэлж буй. Өөрөөр хэлбэл, АН-ынхан сошиал медиа буюу фэйсбүүк, твиттерээр сурталчилгаа хийгээд л ялалт авчихна гэж итгэж байв. Харамсалтай нь сонгуулийн насныхан энэ орчныг тэдийлэн хэрэглэдэггүй. Харин сонгууль өгөхөөс залхуурдаг, хойш суудаг, жил жилийн сонгуульд хамгийн бага буюу 10-20 хувьтай л оролцдог 18-25 насныхан энэ орчинд идэвхтэй байдаг. Буруу тооцож, пиараа зөв хийж чадаагүй учраас ялагдчихлаа. Тэд өдөр тутмын бүх хэвлэл мэдээллийн амыг барьж, зурагтын нэвтрүүлэгт хүртэл цензур тогтоож байв. Өөрөөр хэлбэл, ард түмнийг мэдээллээр хангахгүй байх юм бол ялалт авна гэсэн тактик нь буруу байсныг энэ ялагдал тэдэнд ойлгуулж өгөв. Сониноор сайд, ялаа хоёрыг алж болдог гэдэг үг хэзээ ч хуучрахгүй. Өдөр тутмын хэвлэл гэдэг үнэ цэнээ хэзээ ч алдахгүй гэдгийг АН-ынхан тооцож үзээгүй нь харамсалтай. Хэвлэл мэдээллийн амыг барих бус хийсэн бүтээснээ иргэдэд танилцуулж, ам дамжсан цуурхлын талаар үнэн бодит мэдээллийгардтүмэндээхүргэж байсан бол арай ч ингэтлээ далараа цэвэр тавиулахгүй гэдгийг хэлэхгүй өнгөрч боломгүй биз. Монголчууд бид хэзээнээс л ялсанд нь биш ялагдсаныг нь өрөвддөг ард түмэн. Тиймдээ ч хэн нэгний мууг үзэх гэсэнгүй. Ялагдсан дээр нь дэвсэлхийг ч хүссэнгүй. Гагцхүү дотоодын зөрчлөө арилгаж, намаа шинэчлэх цаг болсныг АН-ын лидер залуус ойлгосон гэдэгт итгэлтэй байна. Тэд ч энэ талаар ярьж, бичиж эхэлсэн нь сайшаалтай. АН-ын өнөөдрийн удирдлагууд мэдээж хариуцлага үүрэх нь тодорхой, хариуцлага үүрнэ гэдгээ ч хэлчихсэн. Гэхдээ нэг удаад даргаа солиод өнгөрөх үү, эсвэл намаа шинэчилж, бодлогын алдагаа засч нам шиг нам болох уу гэдэг л чухал юм. Шинэ дарга тавиад ч өнөөх л фракцийн улс төр, фракцийн дарга нарын амин хувийн эрх ашиг, өс хонзонгоор улс төр хийсээр байвал ирэх дөрвөн жилд дахин ялалт ирэхгүй. Монголын ард түмэн ардчилалд хайртай. Тэд ардчиллын буянаар ямар сайхан амьдрал үзэж байгаагаа мартахгүй, мартаа ч үгүй. Гагцхүү идэх уухаа захирч чадахгүй цөөн хэдэн дарга, хэдхэн улстөрчдийн дотоодын толхилцоон эвдрэлээс залхсандаа иим сонголт хийсэн юм. АН-ын залуус дарга нарыгаа даапалж, ялагдсан дээр нь гишгэлэхийн оронд өөрсдийгөө боловсруулж, улстөрч болоход бэлтгэх цаг нь ирсэн байна. Ялах, ялагдах нь улс төрийн тоглоом хойно ялагдалдаа дүгнэлт хийж дөрвөн жилийн дараа илүү шинэчлэгдсэн нам, илүү бодлоготой улс төрийн хүчин болж төлөвшихийг ард түмэн тэдэнд энэхүү сонголтоороо даалгавар өгөв.

### МАН хэн гэдгээ харуулж чадахгүй бол хэн ч биш болох вий

Улс төр судлаачид, улс төрийн намуудын талаар судалгаа хийдэг олон улсын байгууллагууд иим утгатай мэдэгдэл эхнээсээ хийж эхлэв. Яагаад гэвэл, МАН-д өгсөн ард түмний үнэмлэхүй санал тэдний ирэх дөрвөн жилд хэн гэдгээ харуулах шалгуур болж байгаа юм. Монгол төрийн бодлогыг 90 жил тодорхойлсон улс төрийн нам тун ч хатуу газардаж байсан нь саяхан. Газрын наймаа, авлига, хүнд суртлыг тэд дээд зэргээр цэцэглүүлж, нийслэлийг маань хөгжүүлэх биш хөсөр хаяж байсныг хэн ч мартаагүй. Гэвч өнгөрсөн дөрвөн жилийн уналт тэдэнд олон зүйлийг ойлгуулсан гэж итгэсэн учраас дахиад нэг удаа итгэл үзүүлэв. Харин илүү их хариуцлагатай, эв нэгдэлтэй, дотоод зөрчил биш улс эх орны хөгжлийн төлөө л цаг наргүй ажиллах шаардлагатай болж байна. Өмнөх хийснийг баллуурдаж, эрх барьж байсан нэгнээ үгүйсгэдэг, өш хонзонгийн сэдэлтэй улс төр хийхийг ард түмэн тэвчихгүй. Улстөржилт бус улс орны хөгжлийн төлөө хоёргүй сэтгэлээр ажиллаж чадахгүй л бол МАН дахиад хэн ч биш болно. АН-ын нэг удаагийн ялагдал тэдний хувьд асар том боломж гэдгийг МАН-ын лидер улстөрчид мэдэхийн сайнаар мэдэж буй биз. Тиймдээ ч нийслэлд хийгдсэн их бүтээн байгуулалт, иргэдийг орон сууцжуулах бодлого, хэрэглээ халамжийг шүтсэн мөрийн хөтөлбөр биш үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэх ажлыг хийх учиртай юм. Улсын төсвийг иддэг уудаг, төрийн албыг төрлийн алба болгож завхруулдаг өмнөх алдаагаа дахиад давтаад эхэлвэл энэ удаагийн ялалтаар улс төрийн замнал дуусна гэдгийг сануулах нь илүүц биз ээ. Юутай ч Монголын ард түмэн АН-аас шинэчлэгдэхийг, Ардын намд дахин нэг боломж олгох сонголт хийлээ. Хэн, хэн нь илүү хариуцлагатай байж чадахгүй бол маргааш адилхан л улс төрийн тавцангаас арчигдах билээ. Хатуу боловч үнэн байдал иим л байна. Монголын ард түмэн сонгуульд санал өгч сурчээ. Тэд худлаа амлалтад итгэхээ больчихож. Бас хэдэн халтар цаасаар саналаа худалддаг байхаа больсон байна. Энэ л том ахиц дэвшил байлаа, өнөө жилийн сонгуулийн хувьд.






УРАН БҮТЭЭЛЧ

# Л.Ренчинням: ДАРХАД ДУУГ ПОП ОПЕРА

Н.ПУНЦАГБОЛД

*Монгол түмний дууг нь шимтэн сонсдог хамтлагийн нэг болох монгол поп опера чиглэлээр уран бүтээлээ туурвидаг “Увертюра” хамтлагийн гишүүн Л.Ренчиннямыг уншигч та бүхэнтэйгээ уулзуулах гэж байна. Тэрбээр, хамтлагийнхаа баритон хоолойтой дуучин гэдгийг сонсогч фэнүүд нь андахгүй мэднэ. Дархадын цэнхэр хотгор хэмээх байгалийн сайхан цогцолсон Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын уугуул залуу дуучинтай энэ удаад уран бүтээл болон түүний бага нас, аав ээжийнх нь ажил амьдралын талаар “амттай” яриа өрнүүлсэн юм.*

**-“Увертюра” хамтлагийг эдүгээ мэдэхгүй хүн Монголд цөөхөн. Дуучдыг нь ч эчнээ таньдаг. Гэвч хамтлагийн баритон хоолойтой Л.Ренчиннямын талаар сонсогчид тэр болгон нарийн мэдээлэл байхгүй болов уу. Тиймээс ярилцлагаа өөрийн тань төрсөн нутаг, бага насны тухай дурсамжаас эхлэх үү?**

-Би Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын уугуул. Ренчинлхүмбэ суманд 1986 оны арванхоёрдугаар сарын 14-нд төрсөн. Аав, ээж маань дархад ястан. Аав маань 40 гаруй жил технологийн багшаар ажилласан, багш мэргэжилтэй хүн байсан. 2008 онд бурхан болсон. Дархад нутгийн зон олон “Уран” Ламжий гэдгээр нь илүү сайн мэднэ дээ. Би айлын бага хүү. Миний дээр Ренчиндаваа, Ренчинпүрэв гэж хоёр сайхан ах бий. Ренчинням гэж нэрийг маань Ренчинлхүмбэ суманд ням гарагт төрсөн болохоор тэгж өгсөн юм гэнэ билээ. Манай ах нарыг ч гэсэн төрсөн гарагаар нь нэрлэсэн. Ээж минь насаараа сумандаа сувилагч хийсэн н.Отгон гэж хүн байдаг. Одоо хотод амьдарч байна. Гэхдээ зун болохоор л нутаг орноо санаад байна гээд явчихдаг юм. Би багаасаа л урлаг сонирхдог хүүхэд байлаа. Бага ангиа төгсөөд дуулж эхэлсэн. Бага ангид байхдаа “Хүрээний хөөрхөн Дэнсээ юу” дууг дуулж, сургуулийнхаа аварга болж байлаа. Тэндээс л урлагт дурлаж эхэлсэн дээ. 2005 онд Хөгжим бүжгийн коллежид элсэн суралцаж, ангийнхаа гурван залуутай нийлж хамтлаг байгуулсан юм. Манай гурав чинь гурвуулаа хотынх. Хөдөө төрж, өссөн нь би. Миний бага нас Хөвсгөл далайн эрэг дээр өвс хадаж л өнгөрсөн юм даа. Багадаа хадланд их явна. 2008 оны олимп болж байхад өвс хадаад зогсч байлаа шүү дээ. Оюутан цагтаа жимс их түүдэг байлаа. Сумын төвд үе тэнгийн найзуудтайгаа халтар болтлоол тоглож өслөө.

**-Аав чинь насаараа Ренчинлхүмбэ суманд багшилж байв уу?**

-Ер нь бол тэгж хэлж болно. Цагаан-Уул, Хатгал зэрэг сумдад багшилж байсан. Уран зураг зурдаг, модоор их олон зүйл хийдэг хүн байсан. Тэгээд л нутгийн зон олон “Уран” Ламжий гэж нэрлэсэн юм билээ. Ээж маань Ренчинлхүмбэ сумын уугуул, гуравдугаар багийн Шаргын захад өсч төрсөн хүн. Аав, ээж хоёр маань хоёулаа л энэ нутгийн уугуул. Өнөөдрийг хүртэл миний ах дүү нар Шаргын захаар амьдарч, ажиллаж байна. Улсын сайн малчин “Тайван” Хүүжий гэж хүн миний ах. Улсдаа малаараа их л дээгүүр ордог. Аавын маань дүү Болд гэж хүн одоо ч Шаргын захад амьдарч байна.

**-Нутаг усныхаа талаар яриач. Би очиж үзээгүй л дээ. Гэхдээ үлгэрийн юм шиг сайхан хангай гэж олон хүнээс дуулж байсан?**

-Үлгэрийн юм шиг сайхан хангай гэж төрсөн нутгаа магтчихъя. Дөрвөн зүгтээ уулаар хашаалагдсан сайхан хангай. Урд талд нь Хорьдилын цэнхэр уулс. Хойд талд нь Монгол шарын даваа нь байж байна. Монголынхамгийнөндөр хүрхрээ болох Арсайн хүрхрээ төрсөн нутагт маань байдаг. Өнөө жил Ренчинлхүмбэ сумын 10 жилийн сургуулийн түүхт 90 жилийн ой тохиож байгаа. МУСТА О.Баянмөнх ахтайгаа хамтраад сургуулийнхаа сүлд дууг дуулж байгаа. Манай сургууль чинь “Зууны манлай” кино найруулагч Д.Жигжидийн нэрэмжит. Тун удахгүй нутгаа зорино доо. Ойдоо очиж оролцоно. Би чинь энд суурьшаад гэр бүлтэй болсон ч гэсэн гэрээ санана. Нутгаа санаад л гараад давхичихна шүү дээ.

**-Хамтлагийнхаа түүхээс яриач. Хамтлаг байгуулах бодол яагаад төрөх болов?**

-Бид дөрөв чинь нэг анги. Уг нь тавуулаа байсан юм. Гэхдээ нэг нь хамтлагаасаа гарч ажил, амьдралын шаардлагаар одоо Багахангай дүүргийн Соёлын төвийн дарга хийж байна. Хөгжим бүжгийн коллежи дотроо “Гарын таван хуруу” гэж нэрлэгддэг. Спорт урлагийн олон янзын тэмцээнд бид тав л оролцоно. 2009 онд Ганбаагийн төрсөн өдрөөр анх хамтлаг байгуулах тухай яриа гарч байсан юм. Энэ бодлоо ажил хэрэг болгох гэж явсаар 2011 онд сургуулиа төгсөөд хамтлагаа албан ёсоор байгуулж байлаа. Хамтлаг байгуулахад мэдээж хоолойн өнгө, хөг хэмнэл зохицох эсэх нь чухал. Гэтэл бид тавыг яг л цаанаас нь тохируулчихсан юм шиг таардаг байсан. Манай Ганбаатар тенор, би тенор, Пүрэвдагва тенор, Шинээ баритон гэж явдаг байсан. Хамтлаг болох үндэслэлгүй хоолойтой хүмүүс байлаа. Гэвч курс ахих тусам хүний хоолойн өнгө өөрчлөгдөж эхэлдэг юм билээ. Тэгээд Ганбаа басс баритон, би баритон, Пүрэвдагва хоёрдугаар тенор, Шинээ бүр нэгдүгээр тенор болсон. Ингээд л хамтлагт байх ёстой зарчим, хоолой бүрдчихсэн. Ямар стилиэр уран бүтээл хийх вэ гэдгээ ярилцаад монгол дууг поп опера чиглэлд оруулъя гэж шийдсэн. Ингэж л анхны уран бүтээл болох “Өнө мөнх орон” дууг поп опера чиглэлээр туурвисан. Хамтлаг маань байгуулагдаад зургаан жил болчихлоо. Би хэд хэдэн удаа төрсөн нутагтаа хамтлагтайгаа очиж үнэгүй тоглолт хийж байлаа. Нутгийн зон олон маань манай хамтлагийн үнэнч фэнүүд шүү дээ /инээв/. Урлагийн их тогоонд багтаж яваагийн хувьд нутгийн зон олон, уул ус, аав ээжээ баярлуулах ёстой гэж бодон нутгаа зорин очиж, тоглолтоо хийж байлаа. Хоёр машинтай гараад л давхина шүү дээ.

> ...“Нюанс”-ын ах нар яах аргагүй энэ урсгалыг Монголд оруулж ирсэн хүмүүс. Бидний хувьд ах нараасаа ялгарахын тулд арай өөрөөр сэтгэх ёстой болсон л доо. Тэгээд яагаад монгол дууг поп опера урсгалаар дуулж болдоггүй юм бэ гэж ярилцаад монгол хөгжмийн зохиолч, яруу найрагчийн бүтээлийг поп опера чиглэлээр дуулья гэж шийдсэн...

**-Дуу хуурын өлгий Дундговь гэж ярьдаг. Энэ ч тогтсон ойлголт байлаа. Гэтэл сүүлийн жилүүдэд Хөвсгөл нутгаас олон сайхан дуучид төрөн гарлаа. Ер нь өөрийн тань удамд дуучин хүн бий юу?**

-Удам гэж хэлэхээр ч хүн байхгүй дээ. Гэхдээ манай буурал аав Баатар гэж хүн их сайхан дуучид дуулдаг хүн байсан гэдэг. Адуунд явахдаа их дуулдаг байсан гэнэ билээ. Манай гэр бүлд надаас өөр дуулдаг хүн байхгүй. Хүн аав, ээжийнхээ авьяасыг өвлөдөг гэдэг. Манай ах нар гайхалтай гоё зурдаг. Нэг нь аавын мэргэжлийг өвлөж дизайнер мэргэжлээр ажилладаг. Миний хувьд урлаг, уран сайхны талаар аавынхаа талын авьяасыг өвлөсөн юм болов уу гэж боддог. Оолон ч аймгаас сайхан дуучид төрөн гарч байгаа. Манай Хөвсгөлийн


## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2016.07.01
**Гэрээний нэр, дугаар:** МИАТ ТӨХК-ийн агаарын хөлгийн иж бүрэн даатгалын гэрээ
**Тендерийн нэр, дугаар:** МИАТ ТӨХК-ийн агаарын хөлгийн иж бүрэн даатгалын тендер 15/2016-М

“МИАТ” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдыг “МИАТ” ТӨХК-ийн агаарын хөлгийн иж бүрэн даатгалын үйлчилгээ үзүүлэх тухай битүүмжлэл бүхий тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн бичиг баримтыг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр 50,000 (тавин мянга) төгрөгөөр, эсхүл үүнтэй дүйцэхүйц дүн бүхий чөлөөтэй хөрвөх валютыг “МИАТ” ХК-ийн кассанд тушааж, доорх хаягаар худалдан авах боломжтой. Сонирхсон оролцогчид дэлгэрэнгүй мэдээллийг энд дурдсан хаягаар хандан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба тендерийг саналын 2%-тай тэнцэх төгрөгийн, эсхүл үүнтэй дүйцэхүйц дүн бүхий чөлөөтэй хөрвөх валют бүхий тендерийн баталгаатай хамт ирүүлнэ.

Тендерийг 2016.08.03-ны өдрийн 10:00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх бөгөөд тендерийг 2016.08.03-ны өдрийн 10:30 цагт уг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан нийтийн өмнө нээнэ.

**Гадаадын хуулийн этгээд тендерт оролцох боломжтой.**

**ХАЯГ: Хан-Уул дүүрэг 10-р хороо**
**“МИАТ” ХК**
**Харилцах утас 7004-9860**
**Факс 976-11-7004-9919**
**Өрөөний дугаар : Хангамж, үйлчилгээний хэлтсийн 103 тоот**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2016.07.01
**Тендер шалгаруулалтын нэр:** Агаарын хөлгийн шатахуун нийлүүлэх компани сонгон шалгаруулах тендер
**Тендер шалгаруулалтын дугаар:** 16/2016-М

МИАТ ХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос агаарын хөлгийн шатахуун нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Багц №1 Агаарын хөлгийн 12.000 тонн шатахуун Улсын хил нөхцөлөөр нийлүүлэх.

Багц №2 Агаарын хөлгийн 12.000 тонн шатахууныг Дамжуулан хадгалах, агуулахын үйлчилгээ үзүүлэх.

Багц №3 Агаарын хөлгийн 12.000 тонн шатахууныг тээвэрлэх, хадгалах, агаарын хөлгийг сумлах үйлчилгээ үзүүлэх.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 төгрөгийг “МИАТ” ХК-ийн төв байрны кассанд тушааж доорхи хаягаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй.

Тендерийн хамт Багц №1 392,000,000,00 төгрөг, Багц №2 11,000,000,00 төгрөг, Багц №3 38,600,000,00 төгрөг тус тус тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2016 оны 8-р сарын 01-ний өдрийн 11.00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 8-р сарын 01–ны өдрийн 11.30 цагт нээнэ.

**Гадаадын хуулийн этгээд тендерт оролцох боломжтой.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.*

**ХАЯГ: Хан-Уул дүүрэг 10-р хороо**
**МИАТ ХК**
**Харилцах утас 7004-9860**
**Факс 976-11-7004-9919**
**Өрөөний дугаар : Хангамж, үйлчилгээний хэлтсийн 103 тоот**

ЭНТЕРТАЙНМЭНТ

# УРСГАЛД ОРУУЛЖ ДУУЛАХ НЬ МИНИЙ МӨРӨӨДӨЛ

дуучид уул ус ихтэй, байгалийн сайхан үзэсгэлэнд байдаг учраас арай өөр дуугардаг гэж хэлдэг юм билээ. Манай Дархад дуу хүртэл их өвөрмөц. Дуу эхлэхдээ ихэвчлэн дээд өнгөнөөс эхэлдэг. Өндөр уулаа харж дуулсаар байгаад нот нь хүртэл өндөр байдаг юм болов уу гэсэн яриа байдаг юм билээ. Уул устай нь холбож хүчтэй бөхчүүд, хүчтэй дуучин төрдөг гэсэн яриаг би хувьдаа үгүйсгэдэггүй. Тэглээ гээд бусад дуучдаа үгүйсгэсэн хэрэг биш шүү. Нутгийн онцлогийн тухайд асуусан учраас л хариулсан хэрэг.

**-Поп опера урсгалыг “Нюанс” хамтлаг анх таниулж байлаа. Энэ урсгалыг монгол дуутай холбож дуулна гэхээр зарим хүмүүсийн хувьд сонин сэдэв байх. Поп опера урсгал монгол дуутай төгс нийлж чадаж байна уу?**

-“Нюанс”-ын ах нар яах аргагүй энэ урсгалыг Монголд оруулж ирсэн хүмүүс. Бидний хувьд ах нараасаа ялгарахын тулд арай өөрөөр сэтгэх ёстой болсон л доо. Тэгээд яагаад монгол дууг поп опера урсгалаар дуулж болдоггүй юм бэ гэж ярилцаад монгол хөгжмийн зохиолч, яруу найрагчийн бүтээлийг поп опера чиглэлээр дуулъя гэж шийдсэн. Мэргэжлийн дуунууд бас байна. Шарав гуайн мундаг бүтээлүүд поп опера урсгалд хөрвүүлэх бүрэн боломжтой. Тухайлбал, “Өнө мөнх орон” поп опера урсгалд оруулах гэж нэлээд хичээсэн уран бүтээл. Бид мэргэжлийн сургууль төгссөн учраас мэргэжлийн уран бүтээл хийх сонирхолтой байдаг. Түүнийгээ орчин цагийн хөгжмийн урсгалтай холбоод поп опера гээд явахаар илүү дөхөм. Дан опера чиглэлээр явж болно л доо. Гэхдээ үзэгч биднээс юу хүсч байна түүнийг мэдэрч уран бүтээлээ хийх нь чухал.

**-Бүх л дууг поп опера урсгалаар дуулж болохгүй биз дээ?**

-Болохгүй. Өөрчилж дуулах боломжтой дууг бид сонгоод, захиалдаг. Тухайлбал, Шарав гуайн “Өнө мөнх орон”-оос гадна “Илүү сартай зун” кинонд эгшиглэдэг “Цагийн аяс” гээд аялгуунд Д.Сосорбарам ах үг бичээд дуулахад яг л поп опера болж байгаа юм. Бид ихэвчлэн эх орны сэдэвтэй дуу дуулдаг. Гэхдээ “Хүний заяа”, “Аав ээж хоёр минь” гэх мэт мэргэжлийн уран бүтээлүүд поп опера чиглэлээр дуулахад илүү хэмнэлтэй байдаг.

**-Дуучид нутаг усныхаа талаар олон сайхан уран бүтээл туурвидаг. Чиний хувьд өсч төрсөн Хөвсгөл нутгийнхаа талаар поп опера чиглэлийн уран бүтээл туурвих бодол байдаг уу?**

-Байлгүй яах вэ. Ялангуяа Дархад дууг поп опера урсгалд оруулж дуулах бүрэн боломжтой. Миний мөрөөдөл гэж хэлж болно доо. Мөрөөдлөө ажил хэрэг болгохын тулд судалгааны ажил хийгээд явж байна. Уран бүтээл хийгээд явж байхад дархад дуугаа сайн мэдэхгүй байх тохиолдол надад гарч байсан. Иим зүйл байж болохгүй гэж өөртөө шаардлага тавьж сүүлийн үед унаган нутгийнхаа дуу хуурыг илүү их судалж, суралцаж явна. Төсөл хийх гэж бодоод л явж байна. Хэтэрхий эрт зарлачихвал болохгүй байх л даа. Нууц хэвээр үлдээчих үү.

**-Төрсөн нутгийнханд чинь тун гэнэтийн мэдээ байх байлгүй дээ?**

-Задлахгүй ээ. /инээв/. Нарийн цохилоо, аялгуу зэргийг нь алдагдуулахгүй гаргахын тулд их хичээх ёстой юм билээ. Тиймээс судалгаа их шаардаж байна. Суралцах зүйл ч их байна. Урианхай түмний дуу “Самгалдай” тухайлбал поп опера чиглэлээр дуулах бүрэн боломжтой. “Сэнжтэй дөрөө”, “Далийн цэцэг” гэх мэт олон ч дархад ардын дууг поп опера урсгалаар дуулах гэж судлаад, суралцаад явж байгаа.

**-Соло уран бүтээл урын санд чинь хэр олон байна?**

-Байлгүй яах вэ. Хөвсгөл аймгийн уран бүтээлчид, тэр дундаа Ренчинлхүмбэ суманд багш,захирлаар ажиллаж байсан Я.Баатар гуайн бичсэн сайхан шүлгээр, АБТА н.Сэргэлэн ахынхаа аялгуугаар хийсэн уран бүтээл гаргаж байлаа. “Зөөлөн уул” гэх сайхан уран бүтээлийг Зөөлөн ууланд хөшөө болгож мөнхлөх ажил хийгдэж байгаа. Нотыг нь би саяхан бичиж өглөө. Ренчинлхүмбэ сумын хүн бүхний мэдэх Б.Баасансүрэнгийн аялгуу, аав нь болох н.Баярсайханы үг “Аяны шувууд”, “Нутаг минь” гэх мэт олон сайхан уран бүтээлийг хамтлаг байгуулахаас өмнө оюутан байхдаа дуулсан. Дуучин болмоор байна гээд л ахаасаа мөнгө гуйгаад нутгийнхаа уран бүтээлийг гаргадаг байлаа. Хамтлагаа байгуулснаас хойш соло уран бүтээл хийх боломж бараг л үгүй болсон. Хамгийн сүүлд Хөвсгөл аймгийн Газрын дарга н.Бямбадоржийн үг, Цэн.Эрдэнэбатын аялгуу “Хөвсгөлийн барилгачид” гэх уран бүтээлийг Хөвсгөл аймгийн Барилгын хэлтсийн дарга н.Энхжаргал эгчтэйгээ хамтраад гаргалаа. Мөн МУГЖ Ө.Уянга эгчтэй хамтран “Хөх сувдын орон” гэж сайхан уран бүтээл туурвисан. Энэ уран бүтээл маань мөн л Цэн.Эрдэнэбатын аялгуу, Жанхай нэрээр алдаршсан Даваадамдин ахын үг.



**-Хамтлагийн хувьд уран бүтээлийн арвин олзтой байгаа. Томоохон мюзикл тоглосон. Уран бүтээлийн олз омгоосоо манай уншигчидтай хуваалцаач?**

-Тэгэлгүй яах вэ. Энэ оны нэгдүгээр сарын 22, 23, 24-нд Улсын драмын эрдмийн театрт “Надад үлдсэн найз” мюзикл тоглолоо. Зоригтой шийдвэр гарган тоглосон маань маш амжилттай болсон. Гуравдугаар сарын 18-нд “Монгол цэргийн баяр”-аар мөн үзэгчдийнхээ хүсэлтээр дахин тоглосон. Одоо энэхүү мюзиклийнхээ цомгийг гаргах, мөн хоёр дахь цомгоо гаргахаар ажиллаж байна.

**-Мюзикл дуулах, жүжиглэх ур чадварыг дуучнаас шаарддаг. Хэр их бэрхшээлтэй тулгарав?**

-“Милл” кино компани бидний захиалгаар бүтээсэн. Өөрт чинь анх “Бид мюзиклийн дуучид болно” гэж ярилцлага өгч байснаа санаж байна. Тэгээд л хэлсэн амандаа хүрч “Милл” кино компанийн н.Лхагважаргал ах найруулж, н.Мөнхбат ах зохиолыг нь бичиж бид дөрөвт зориулж “Надад үлдсэн найз” гэх уран бүтээлийг хийлээ. Хөгжмийн зохиолчоор “Анир” студийн Б.Алтанхуяг ах ажиллаж, үгийг нь Л.Таванбаяр найруулагч хийсэн. Аливаа уран бүтээлчид дангаараа мюзикл босгоно гэдэг төсөв мөнгөнөөс эхлээд хүндрэлтэй байлаа. Их ч хичээлээ. Мэргэжлийн жүжигчид болох Төрийн соёрхолт жүжигчин Ц.Төмөрбаатар ах болон бусад уран бүтээлчидтэй хамтраад хийж чадсан. Мэргэжлийн жүжигчид маань их зааж зөвлөж байсан шүү.

МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ
Манай сонины III улирлын захиалга үргэлжилж байна
Улиралд 44 дугаар
захиалгын үнэ 15400
Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай post: 70121294
Түгээмэл шуудан: 70115025



# ДЭЛХИЙ

СОНГУУЛЬ-2016

# УИХ-ЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ ГАДНЫ ХЭВЛЭЛД


Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

### Nikkei: Сонгуулийн системийг өөрчилсөн нь МАН ялалт байгуулахад нөлөөлсөн

Японы "www.nikkei.com" сайтад мөн л Монголын сонгуулийн талаар ийм мэдээлэл тавигджээ. Уг мэдээллийг хөрвүүлбэл, "Монголын парламентын сонгуульд хамгийн том сөрөг хүчин болох МАН хамгийн олон суудал авч, үнэмлэхүй ялалт байгууллаа. Харин эсрэгээрээ эрх баригч Ардчилсан нам маш бага суудал авч, ялагдал хүлээсэн байна. МАН ойрын хугацаанд шинэ Ерөнхий сайд болон УИХ-ын даргаа томилох бөгөөд эрх баригч намын эдийн засгийн бодлого, авлигатай холбоотойгоор иргэд тус намд итгэл алдарчээ. Энэ нь сөрөг хүчнийг ялалт байгуулахад нөлөөлжээ. СЕХ-ны өнөөдөр өглөө зарласан дүн мэдээллээс үзвэл МАН 65 суудал авсан байна. Тус нам өнгөрсөн удаагийн сонгуульд 30 суудал авч байсан билээ. Харин 2012 оны сонгуульд 38 суудал авч байсан Ардчилсан нам энэ удаа ердөө есөн суудал авч, Ерөнхий сайд Ч.Сайханбилэг хүртэл тойрогтоо бүдэрчээ. Сонгуулийн үр дүнг санал хураалт болсон өдрөөс хойш 15 хоногтоо багтаан Ерөнхийлөгчид тайлагнадаг. Энэ удаагийн сонгуулийн ирц сайн, 72.1 хувьтай байлаа. МАН-ын дарга М.Энхболд сонгуулийн урьдчилсан дүн гарсны дараа хэвлэлийн хурал хийж, "Итгэл хүлээлгэсэн ард түмэндээ талархал илэрхийлье" хэмээн ялалтаа албан ёсоор зарласан. Орон нутгийн мэдээллийн сайтуудын мэдээлж буйгаар Ардын нам ирэх сард болох баяр наадам хүртэл Ерөнхий сайдаа сонгож, Засгийн газраа бүрдүүлэх аж. Нөгөө талаар Ардчилсан нам "Сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрч байна. Амаргүй дөрвөн жил байлаа" хэмээн ялагдлаа хүлээн зөвшөөрөв. Монголын эдийн засгийн өсөлт буурсны улмаас сонгогчид Засгийн эрх барьж буй намд итгэл алдарчээ. Мөн сонгуулийн системийг өөрчилж, жижиг мажоратори систем рүү хөрвөсөн нь МАН сонгуульд ялалт байгуулахад нөлөөлсөн байх магадлалтай байна" хэмээн бичжээ.

### Financial times: Дараа жилээс Монгол өрөө төлж эхэлнэ

"Financial times" сайтад доорх мэдээлэл нийтлэгджээ. Үүнийг орчуулбал, "МАН парламентын сонгуулийн санал хураалтад үнэмлэхүй ялалт байгуулж, эдийн засаг доройтсон дөрвөн жилийн дараа Засгийн эрхийг эргүүлэн авлаа. Ардчилсан намын тэргүүлсэн эвслийн Засгийн газар гадаадын компаниудад хөрөнгө оруулалтын орчныг сайжруулсан хэдий ч, хэмнэлтийн бодлого хэрэгжүүлж чадаагүй. Харин үүний оронд гадаадын шууд хөрөнгө оруулалт буюу орлого буурсны улмаас улсын өр нэмэгдсэн байдаг. Гол хоёр экспортын бүтээгдэхүүн болох нүүрс, зэсийн үнэ дэлхийн зах зээлд унасны улмаас эдийн засаг нь хүнд байдалд орсон улсын нэг бол Монгол. Үүнээс гадна өмнөд хөрш Хятад улсын эдийн засгийн өсөлт саарснаар төрийн болон хувийн хэвшлийн өр үндэсний орлогыг уналтад оруулж байна. Дараа жил гэхэд тус улс төрийн болон хувийн хэвшлийн хоёр тэрбум ам.доллар, Хятадын Ардын банктай байгуулсан своп хэлцлийн 2.3 тэрбум ам.долларыг төлж эхлэх учиртай. Гэвч энэ Засгийн газар өрийн талаар яаралтай арга хэмжээ авахаас зайлсхийж ирсэн байдаг. Хэд хэдэн фракци болж хуваагдсан ардчилагчдын ихэнх нь парламент дахь суудлаа алдсан бөгөөд тэдний дунд Ерөнхий сайд Ч.Сайханбилэг ч багтаж буй. Британи, Колумбын их сургуулийн Монголийн улс төр, нийгэм судлаач Жулиан Диеркэсийн бичсэнээр ирэх дөрвөн жилд Засгийн газар тогтвортой байж, эдийн засгийн үр нөлөө нэмэгдэж магадгүй гэнэ. Түүний хэлснээр МАН Ардчилсан намтай харьцуулахад харьцангүй дэг журамтай нам ажээ" гэсэн байна.

### www.infpol.ru: Бие даагчдаас С.Жавхлан ганцаараа сонгогдов

Оросын "infpol.ru" сайтад Монголын сонгуулийн талаар бичжээ. Үүнийг монгол хэлнээ хөрвүүлбэл, "Монголын парламентын сонгуулийн санал хураалт зургадугаар сарын 29-ний өдрийн 22:00 цагт албан ёсоор хаагдсан бөгөөд автомат системийн ачаар сонгуулийн дүн хагас цагийн дараа гэхэд СЕХ-ны хэвлэл мэдээллийн төв дэх том дэлгэц дээр гарч эхэлсэн. Эхэндээ эрх баригч Ардчилсан нам болон МАН-ын нэр дэвшигчдийн санал хоорондоо маш ойрхон зөрүүтэй явж байсан ч, шөнө дунд болоход Ардчилсан нам эрх мэдлээ алдах нь нэгэнт тодорхой болсон юм. Казахууд хүн амын ихэнхийг эзлэх Монголын баруун хязгаарын Баян-Өлгий аймгийн сонгуулийн дүн хараахан ирээгүй байсан ч, МАН-ын нэр дэвшигчид ээлж дараалан тойрогтоо ялалт байгуулж байлаа. Тиймдээ ч, МАН парламентын 76 суудлын 63 суудлыг авахад гайхаад байх зүйлгүй байв. Бие даагчдаас цорын ганц хүн сонгогдсон нь дуучин С.Жавхлан. Түүнийг Буриадад "Хамаг Монгол" төслийн зохион байгуулагч гэдгээр нь илүү мэддэг. Сүүлийн үед түүний дуунууд Буриадад дэлгэрч, ялангуяа "Ээжийн чанасан цай" дуу нь хит болж байгаа юм. Улс төрийн мэдлэг муутай хэдий ч, шударгаар өрсөлдсөн түүнд сонгогчид нь итгэл хүлээлгэсэн. Тэрбээр өрсөлдөгчдөөсөө хоёр дахин илүү санал авч үнэмлэхүй ялалт байгуулсан юм. Мөн хамгийн гайхалтай нь нэр хүнд нь унасан экс Ерөнхийлөгч Н.Энхбаярын тэргүүлдэг Монгол Ардын хувьсгалт намын ердөө нэг нэр дэвшигч нь сонгогдсон. Харин Ардчилсан нам нийт 11 суудал авлаа" гэжээ.

### www.reuters.com: МАН парламентад хамгийн олон суудал авч, Ардчилсан намаас засгийн эрхийг эргүүлэн авлаа

www.reuters.com сайтад "Монголын гол сөрөг хүчин МАН парламентын сонгуульд ялалт байгуулж, эрх мэдлээ эргүүлэн авснаа зарлалаа. 1990 оны тайван хувьсгалаас хойш байгалийн баялгийн арвин их нөөцтэй тус улс гадаадын хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж, 2010-2012 онд эдийн засаг нь оргил үедээ хүртлээ өссөн байдаг. Гэвч 2012 оноос хойш Рио Тинто зэрэг уул уурхайн компаниудтай хийсэн маргааны улмаас эдийн засгийн өсөлт нь буурч, эцэстээ өнгөрсөн сард Оюутолгойн далд бүтээн байгуулалтын 5.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтын төслийг баталж байсан. Тэгвэл МАН парламентад хамгийн олон суудал авч, Ардчилсан намаас засгийн эрхийг эргүүлэн авлаа. Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлд хөөсрөлт үүсээд байсан үед "Mine-golia" хэмээн нэрлэгдэж явсан гуравхан сая хүн амтай тус улсын сонгуульд МАН ялахад хөрөнгө оруулагчдын төөрөгдөл тусалсан гэж хэлж болно. Гэхдээ одоогоор тэд зэс, нүүрсний эрэлт буурсны улмаас өргөн хэрэглээний барааны үнийн өсөлттэй дасан зохицохоор хичээж буй. Ямартай ч, Олон улсын Валютын сан 2011 онд 17.5 хувийн өсөлттэй байсан Монгол Улсын эдийн засгийн өсөлт энэ онд 0.4 хувьтай гарна гэж таамаглаж байна" гэсэн байна.



# Дэвид Камероныг ХЭН ЗАЛГАМЖЛАХ ВЭ

Б.ДАВААХҮҮ

Их Британид Европын холбооноос гарах эсэх асуудлаар бүх нийтийн санал асуулга энэ сарын 23-ны өдөр зохион байгуулагдсан. Улмаар иргэдийн дийлэнх нь ЕХ-ноос гарах сонголтыг хийсэн байдаг. Үүний дараа ЕХ-той тусгай статустайгаар үлдэх талаар хэлэлцээр хийж байсан Их Британийн Ерөнхий сайд Дэвид Камерон ирэх намар огцорно гэдгээ албан ёсоор зарласан билээ. Тэгвэл түүний албан тушаалд горилогчдын нэрс эдүгээ аль хэдийнэ тодроод эхэлжээ. Өнгөрсөн жилийн тавдугаар сард явагдсан парламентын бүх нийтийн сонгуулиар Дэвид Камероны тэргүүлэх Консерватив нам ялалт байгуулж, кабинетаа бүрдүүлсэн. Тиймээс дараагийн Ерөнхий сайд ч тус намаас төрөх учиртай. Тэгвэл дэлхийн томоохон эдийн засагтай орнуудын нэг болох Их Британийн Ерөнхий сайдад 59 настай Дотоод хэргийн сайд Тереза Мэй нэрээ дэвшүүлжээ.

"Таймс" сонинд нийтлэгдсэн мөрийн хөтөлбөрөөс нь харвал, улстөрч бүсгүй хэрвээ Ерөнхий сайд болбол Их Британийг эв нэгдэлтэй байлгахаа амлаж буй аж. ЕХ-ноос гарах эсэх асуудалд Дэвид Камерон үлдэхийг дэмжиж байсан бөгөөд Тереза Мэй ч түүнтэй ижил байр суурьтай байв. Гэхдээ санал асуулгын өмнөх улс төрийн хүчнүүдийн кампанит ажиллагааг зохицуулах үүрэг гүйцэтгэж, сөргөлдөөн бүхий хоёр талыг нэгтгэж байсан нь Ерөнхий сайд болоход хамгийн тохирох хүн гэх дүгнэлтийг хийхэд хүргэжээ. Мэй нэр дэвшүүлэхийг хүссэн бичигтээ "Их Британийг бүх л ард түмэндээ үйлчилдэг улс болгохын төлөө зорьж ажиллана" гэдгээ онцолсон байна. Тереза Мэй Дотоод хэргийн сайдаас гадна Лондон хотын экс захирагч Борис Жонсон Ерөнхий сайдад нэр дэвшиж буй. Тиймээс ч Тереза Мэйний хувьд жирийн пасторын гэр бүлд төрсөн гэдэг утгаараа цэнхэр цамцтанууд руу бодлогоо чиглүүлж байна.

Тереза Мэй 2010 оны бүх нийтийн сонгуульд Консерватив нам ялалт байгуулсны дараа Дотоод хэргийн сайдаар томилогдон, Дэвид Камероны Засгийн газарт орж ажилласан байдаг. Улмаар 2015 оны сонгуулиар ч гэсэн Дотоод хэргийн сайдаар улиран томилогдож, цагаачдын эсрэг хатуу бодлого баримтлах болсон юм. Түүний туушгай зан чанар, гадаад төрх 1980 оны тус улсын Ерөнхий сайд Маргарет Тэтчерийг санагдуулдаг хэмээн хүмүүс үнэлдэг байна. Харин гадаад төрхөөрөө АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Доналд Трампыг санагдуулах 53 настай Борис Жонсон Британийн санал асуулгад ЕХ-оос гарахыг дэмжигчдийн нэг байсан юм. Нийгмийн дундаж давхаргаас гаралтай тэрбээр зарим илтгэлээ латин хэлээр тавих зэргээр дээд давхаргынхны имижийг харуулдаг гэх шүүмжлэл байна. Улстөрч, нэр хүндтэй түүхч, бас сэтгүүлч тэрбээр 2015 оноос парламентад суух болсон. Түүний хувьд 2008-2016 онд Лондон хотын Захирагчаар ажиллаж байв.

Борис Жонсоныг Их Британийн улс төрийн эрин үеийг тэргүүлэгч гэж үнэлдэг бөгөөд жилийн 50 мянган ам.долларын төлбөртэй сургуульд өндөр боловсрол эзэмшсэн гэдгээрээ ч консервантчууд дундаасаа тод ялгардаг байна. Энэ мэт хоёр улстөрч Дэвид Камероныг залгамжлахаар өрсөлдөж байна. Шинэ Ерөнхий сайд ирэх есдүгээр сарын эхээр томилогдох ажээ. Ямартай ч, эхлээд Борис Жонсон болон Тереза Мэй нарын алийг нь Ерөнхий сайдад томилох эсэх асуудлаар парламент дахь 330 гишүүний дунд санал хураалт болох учиртай. Энэ санал хураалтад хамгийн олон санал авсан нэр дэвшигч намын 150 мянган гишүүдээр батлуулна. Улмаар гишүүдийн ихэнх нь итгэл хүлээлгэсэн тохиолдолд тухайн нэр дэвшигч Консерватив намын дарга болоод зогсохгүй Ерөнхий сайдын суудалд томилогдож, Дэвид Камероныг залгамжлах юм.

## Филиппиний Ерөнхийлөгч тангарагаа өргөлөө

Филиппиний Ерөнхийлөгчийн сонгуульд сонгогчдын итгэлийг хүлээж сонгогдсон 71 настай Родриго Дютерт өчигдөр тангарагаа өргөлөө. Түүний Ерөнхийлөгчийн тангарагаа өргөх ёслолын ажиллаг нийслэл Манила хот дахь Ерөнхийлөгчийн ордонд болжээ. Тангараг өргөх ёслолын ажиллагаа эдүгээг хүртэл ард олны өмнө өргөн хүрээтэй зохион байгуулагддаг байсан бол Дютерт энэ уламжлалыг эвдэж, ордонд цөөхөн хэдэн хүнийг байлцуулан ёслолыг гүйцэлдүүлсэн байна. Түүний бүрэн эрхийн хугацаа зургаан жил үргэлжлэх ажээ. Тэрбээр өмнө нь Давао хотын захирагчаар ажиллаж байхдаа гэмт хэрэгтнүүдтэй туушгай тэмцэж, "шийтгэгч" гэх хочийг хүртсэн байдаг.

Харин өнгөрөгч тавдугаар сард болсон сонгуульд ялалт байгуулсныхаа дараа тэрбээр гэмт хэрэгтнүүдтэй хатуу тэмцэхээ амласан. Юуны түрүүнд аюулгүйн албаны хууль тогтоомжид өөрчлөлт оруулан цаазын ялыг сэргээнэ гэж мэдэгдсэн удаатай. Үүнээс гадна гэмт хэрэгтнүүд эсэргүүцэл үзүүлсэн тохиолдолд галт зэвсэг ашиглах эрхийг цагдаагийн байгууллагад өгч, хар тамхины наймаачдыг хөнөөсөн хуулийн байгууллагынхныг шагнаж урамшуулдаг болох талаар үг унагаж, олны анхаарлыг татаж байсан юм. Түүнчлэн, насанд хүрээгүй хүүхдүүдийг шөнийн цагаар гадуур явах болон 00:00 цагаас хойш архи, согтууруулах ундаа зарж борлуулахыг хориглох зэрэг арга хэмжээ авна хэмээн ярьж байв. Ямартай ч, тэрбээр өчигдөр тангарагаа өргөж, үүрэгт албандаа томилогдлоо. Цаашид ямар шийдвэр гаргах нь дэлхий нийтийн анхаарлын төвд байна.

# ШУУРХАЙ МЭДЭЭ

## Хууль зөрчсөн түргэн үйлчилгээний төвүүдийг нүүлгэнэ

АСЕМ-ын уулзалт Улаанбаатар хотод болох гэж байгаатай холбогдуулан зочид төлөөлөгчдийн аюулгүй байдлыг хангах үүднээс 13 гудамжны зам дагуу байрлаж буй түргэн үйлчилгээний цэгүүдийг нүүлгэж байна. Иргэн, аж ахуйн нэгжүүд нүүлгэсэн түргэн үйлчилгээний цэгүүдээ 2016 оны долдугаар сарын 20-ноос хойш зөвшөөрсөн байршилд буцааж тавих боломжтой аж. АСЕМ-ын хурлыг зохион байгуулах Үндэсний зөвлөлөөс тавьж байгаа шаардлагын дагуу түргэн үйлчилгээний цэгүүдэд шаардах хуудас хүргүүлж, албадан нүүлгэж байгаа боловч зочид төлөөлөгчид зорчих зам маршрутын дагуу дур мэдэн дахин байршуулж, хууль бус үйлчилгэээр хэлж байгаа гэнэ. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулиар аж ахуйн нэгж, албан тушаалтан төрийн тусгай хамгаалалтад шаардлагатай туслалцаа үзүүлэх үүрэгтэй. Төрийн байгууллагын албан шаардлагыг удаа дараа биелүүлээгүй, төрийн тусгай хамгаалалтын хуулийг зөрчсөн иргэн аж ахуйн нэгжид хатуу хариуцлага тооцож, албадан нүүлгэхийг анхааруулав.

## Ханын материалд сургууль, цэцэрлэг барих зургаан га газар олгов

Нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл "Газар эзэмших эрх олгох тухай" захирамж гаргажээ. Захирамжаар газар эзэмших эрхийн төсөл сонгон шалгаруулалтад оролцож шалгарсан "Тэвхэн" ХХК-д сургууль цэцэрлэг барих газрын зөвшөөрлыг олгосон байна. Тодруулбал, тус компанид Сонгинохайрхан дүүргийн долдугаар хорооны нутаг дэвсгэрт Ханын материалын үйлдвэрийн зүүн талд 6.0 га газрыг сургууль, цэцэрлэг бүхий орон сууцны цогцолбор хорооллын зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмших эрх олгосон аж. Тус захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Засаг даргын Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан орлогч С.Очирбатад даалгажээ.

# ПРОТЕЗИЙН ХЭРЭГСЛИЙГ ГАДААДАД ХИЙЛГЭЖ БОЛНО

Н.БАТЗАЯА

*Нийслэлийн нийгмийн халамж, үйлчилгээний газрын Ахмад настны асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Сугараас протез, ортопедийн хөнгөлөлтийн талаар зарим зүйлийг тодрууллаа.*

**-Ахмад настанд үзүүлэх протез, ортопедийн хөнгөлөлтийн талаар мэдээлэл өгөхгүй юу. Ямар хэрэгсэлд хөнгөлөлт авах боломжтой вэ?**

-Ахмад настны Нийгмийн хамгааллын тухай хуульд хөл, гар, шүдний протез, сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл худалдан авсан болон дотоодод хийлгэсэн зардлын үнийг хөнгөлөх, нөхөн олгох тухай заасан байдаг. Тодруулбал, сүүж-түнхний үе, өвдөгний үе, дунд чөмөг, шилбэ, шилбэний түгжээ хадаас, тавхай, тавхайн урд хэсэг, мөр, бугалга, шуу, сарвуу, хуруу, хиймэл шүдийг хамруулдаг. Мөн эрүү, сонсголын дижитал аппарат, дунд чихний титан зэрэг протезийн хэрэгслийг хөнгөлөлттэй хийлгэх боломжтой. Харин ортопедийн хэрэгслээс харааны шил, +5 болон -5 ба түүнээс дээш контакт линз, шилэн болон хуванцар нүд, нүдний болор, хөл, гарын чиг, нурууны бэхэлгээ, тэргэнцэр, алхуулагч, таяг, суултуур, хөтөвчийг нэг удаа ахмад настанд нөхөн олгодог юм.

**-Ямар газруудад хийлгэх боломжтой вэ. Гэрээтэй газрууд байдаг уу?**

-Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд протез болон ортопедийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй 12 байгууллага бий. Тухайлбал, "ЭМЖЖ", "Баянгол мед", "Тунгалаг аялгуу", "Доктор тун", "Мон-Анир", "Дэл-Оюу-Дөл", "Мэбрүг", "Дулаан хайрхан трейд", "Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо", "Тэгш оршихуй", "Тавин ус", "Отгонбуянт хүрээ" зэрэг компаниуд протез болон ортопедийн хэрэгслийн үйлчилгээ үзүүлнэ.

**-Эдгээр компаниас протез, ортопедийн бүх тусламж үйлчилгээг авч болох уу. Хүссэн компанидаа захиалгаа өгөх үү?**

-Компани бүр багцтай. Багцынхаа дагуу үйлчилгээ үзүүлнэ л дээ. Тодруулбал, "ЭМЖЖ" компани Баянзүрх дүүргийн ахмадуудад сонсголын аппаратын үйлчилгээ үзүүлдэг. Мөн Чингэлтэй дүүргийн ахмад настанд сонсголын дижитал аппарат олгодог. Харин "Баянгол мед" компани Сүхбаатар дүүргийн иргэдэд сонсголын дижитал аппарат, Баянгол, Багануур, Багахангай, Налайх дүүрэгт смотын уут нийлүүлдэг байгаа. Энэ мэтчилэн шалгарсан багцаар иргэдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг.

**-Протез, ортопедийн хэрэгслийг заавал Монголд хийлгэх үү?**

-Үгүй. Тухайн ахмад настан өөрөө хүсвэл гадаадад хийлгэж болно. Заавал Монголд хийлгэх ёстой гэсэн зүйл байхгүй. Гадаадад хийлгэсэн хүмүүс байдаг.

Гэхдээ гадаадад протез, ортопедийн хэрэгсэл хийлгэсэн ахмад настанд хөнгөлөлт үзүүлэхдээ дотоодод хийлгэсэн ижил төрлийн протез, ортопедийн хэрэгслийн жишиг үнээр тооцож хийлгэнэ. Өөрөөр хэлбэл, хэдийгээр гадаадад хийлгэсэн ч гэсэн дотоодынхоо үнээр бодож хөнгөлөлт олгоно гэсэн үг. Гадаадад хийлгэсэн үнээр тооцож хөнгөлөлт олгохгүй.

**-Тэгэхээр өөрөө хүссэн газраа хийлгэх боломжтой гэсэн үг үү?**

-Тийм. Ахмад настан протез, ортопедийн хэрэгслийг өөрийн сонгосон байгууллагаараа хийлгэж болно.

**-Бичиг баримт бүрдүүлэх шаардлагатай байх. Ямар бичиг баримт бүрдүүлэх вэ. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?**

-Эхлээд өргөдөл бичих хэрэгтэй. Мөн хөдөө орон нутагт амьдардаг бол сумын, төв суурин газар амьдардаг бол хорооны Засаг даргын тодорхойлолт, иргэний үнэмлэхээ хуулбарынхаа хамт авч ирэх ёстой. Протез, ортопедийн хэрэгсэл хийлгэх шаардлагатай гэсэн эмчийн тодорхойлолт, хэрвээ протез хийлгэсэн бол мөнгө төлсөн тухай баримт, эсхүл нэхэмжлэл авч ирэх шаардлагатай. Эдгээр материалыг бүрдүүлж харьяа аймаг, сум, дүүргийнхээ нийгмийн халамж, үйлчилгээний мэргэжилтэнд хандах хэрэгтэй.

**-Протоз, ортопедийн хөнгөлөлтийг таван жилд нэг л удаа олгох уу?**

-Тийм. Таван жилд нэг л удаа олгодог.

## Онцгой байдлынхан 1739 сонгогчид гол гатлахад нь тусалжээ

Ойрын өдрүүдэд ихэнх нутгийг хамран орсон борооны улмаас гол мөрний усны түвшин эрс нэмэгдсэн. Онцгой байдлын ерөнхий газрын харьяа төв, орон нутгийн Онцгой байдлын газраас өчигдөр болсон сонгуулийн үеэр үер, усны ослоос урьдчилан сэргийлэх, албаны бэлэн байдлыг хангах, сонгуулийг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлэх, гол ус гаталж сонгуульд оролцох үед иргэд, сонгогчдын аюулгүй байдлыг хангах шаардлагатай техник хэрэгслийг дайчлан ажиллажээ. Тодруулбал, Архангай аймгийн Цэцэрлэг, Хангай суманд 365, Булган аймгийн Сэлэнгэ, Тэшиг, Сэлэнгэ сумдад 256, Ховд аймгийн Дуут суманд долоо, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Хужирт сумдад 290 иргэнийг гол гатлуулж, аюулгүй байдлыг нь хангаж ажилласан байна. Мөн Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Мандал сумдад 117, Төв аймгийн Алтанбулаг суманд 108, Увс аймгийн Тэс, Завхан, Ховд, Түргэн, Тариалан сумдад 248, Хөвсгөл аймгийн Галт суманд 348 иргэний аюулгүй байдлыг хангаж ажиллав. Түүнчлэн нийт найман аймгийн 17 суманд Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын 86 албан хаагч, 29 техник хэрэгсэлтэйгээр ажиллаж, 1739 сонгогчийг завь болон автомашинаар голоор гаргах, буцаах ажлыг зохион байгуулсан аж.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## 21 хүн зам тээврийн ослын улмаас бэртсэн байна

Улаанбаатар хотын Замын цагдаагийн газрын ЖШҮХ энэ сарын 29-нд нийт 267 дуудлага, мэдээ мэдээлэл хүлээн авсныас зам тээврийн ослын 190 дуудлага бүртгэгдсэн байна. Үүнээс 21 хүн хүнд хөнгөн гэмтжээ. Тодруулбал, БГД-ийн нутаг Хасбаатарын Бичил хорооллын урд замд Benz G550 маркийн авто машины жолооч Э нь Т. RAY-4 маркийн Г жолоочтой авто машинтай мөргөлдөж, жолооч 26 настай эмэгтэй Г нарын дөрвөн хүн гэмтсэн аж. Мөн ЧД-ийн нутаг дэнжийн гудамж, 31 дүгээр цэцэрлэгийн 64 дүгээр тойргийн урд замд T.Probox маркийн авто машины жолооч М нь явган зорчигч 25 настай эрэгтэй С нарын дөрвөн хүнийг мөргөж, гэмтээжээ. Иймд Улаанбаатар хотын Замын цагдаагийн газраас замын хөдөлгөөнд болгоомжтой оролцохыг анхааруулав.

## Мансууруулах бодис хэрэглэж байгаад баригджээ

Машиндаа мансуурч байгаад баригдсан хэрэг гарчээ. Тодруулбал, зургадугаар сарын 29-нд нийслэлийн Баянзүрх дүүргийн дөрөвдүгээр хорооны нутагт дэвсгэр Жуковын талбай дээр 22:00 цагийн үед "ВМВ" автомашинтай хүн уутгай өвс татаж байсан байна. Цагдаагийн алба хаагчид эргүүлийн үүрэг гүйцэтгэж байхдаа шалгахад, Баянзүрх дүүргийн дөрөвдүгээр хороонд суух 26 настай эрэгтэй Э мансууруулах өвс татаж байжээ. Түүний шээсэнд тестээр сорил тавихад мансууруулах бодис хэрэглэсэн нь илэрчээ. Уг хэргийг Баянзүрх дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтсийнхэн шалгаж байгаа ажээ.

## Номын худалдааны төвийн урд талын талбайг тохижуулав

Улаанбаатар хотын 2016 оны хот тохижилт, ногоон байгууламж, инженерийн шугам сүлжээ, зам, засварын ажил, АСЕМ-ын бэлтгэлийг хангах ажлын хүрээнд хийж буй ажилд 22 ажлын хэсэг хяналт тавин ажиллаж байгаа аж. Ажлын хэсгүүд өчигдөр хуралдаж, нийслэлийн хэмжээнд хийж буй тохижилт, ногоон байгууламжийн ажлын талаар санал солилцлоо. Тус уулзалтын үеэр АСЕМ-ын хүрээнд хийгдсэн ажлыг танилцуулсан. Тухайлбал, "Буянт Ухаа-2" хорооллын зүүн талын төв замд буцаж эргэх эргэлт хийж, Наадамчдын уулзварт байрлаж буй Замын цагдаагийн газрын постыг буджээ. Мөн замын хажуу талын далангийн шороог тэгшлэн, хүр хогтой жалгийг бүрэн цэвэрлэн "Торгоны зам" цогцолборт хавтан суурилуулж, Занбазарын гудамжинд гэрэлтүүлэг хийсэн байна. Хурлын дараа ажлын хэсгийнхэн газар дээр нь очиж хийсэн ажлуудтай танилцсан юм. Энэ үеэр Энхтайваны өргөн чөлөө Багшийн хөгжлийн ордны зүүн талд хийсэн явган хүний замын ажлын гүйцэтгэлийг шалгаж, сандал, хогийн саваас гадна голын суурин дээр цэцэг тарьж, "Үнсэлт" нэртэй баримал байршуулахаар боллоо. Мөн Намьянжүгийн гудамжинд хийсэн цэцгэн тохижилтын ажлыг замын зүүн талд үргэлжлүүлэн хийхээр шийдвэрлэсэн юм. Харин Их тойруу буюу Бөмбөгөрийн даланд сувгийн цэвэрлэгээ хийх шаардлагатайг гүйцэтгэгч компанид нь уламжлан, Наадамчдын замд "Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл"-ээр 1200 ам метр талбайд эко хавтан тавиулах ажээ.

PHOTO NEWS



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН



*Энэ жил элсэлтийн ерөнхий шалгалтыг нийт 37200 гаруй шалгуулагч өгчээ. Үүнээс 15123 нь нийслэл, 22041 нь орон нутгийн шалгуулагч байгаа аж. Шалгалтын тестийн түлхүүр үг зургадугаар сарын 21-нд Боловсролын үнэлгээний төвийн цахим хуудаснаа нийтлэгдсэн. Тэгвэл өнөөдөр шалгуулагчдын онооны хариу гарах юм байна.*

# ЗАВСАРЛАГА

ДУУЛГАХ СОНИН

## ӨВӨР МОНГОЛЫН ГЭРЭЛ ЗУРАГЧИД МОНГОЛООР АЯЛНА

Б.САРНАЙ

Монголын Гэрэл зурагчдын нэгдсэн холбооны гишүүн 10 гэрэл зурагчин БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө засах орны Хэвлэл мэдээллийн албаны урилгаар энэ сарын 22-27-ны өдрүүдэд тус улсын 10 гаруй аймаг, хот, тосгоноор хамтарсан сурвалжлага хийж, туршлага солилцох зураг авалтад оролцоод ирлээ.

Тус холбооноос томилон явуулсан энэхүү баг нь Монгол, Хятадын гэрэл зургийн сурвалжлагчдын анхны томоохон хэмжээний уулзалт бөгөөд мэргэжил нэгт нөхөдтэйгөө ур чадвараа сорин өрсөлдөх,хамтынбүтээлгаргах боломжийг бүрдүүлснээрээ онцлогтой юм. ӨМӨЗО-ны нутгаар фоточид хоёр хэсэгт хуваагдан ажилласан бөгөөд баруун хэсгээр Хөх хот, Ордос, Бугат хотын чиглэл, зүүн хойд нутгаар Хайлаар, Хөлөнбуйрын байгалийн



үзэсгэлэнт газрууд, түүхийн дурсгалууд, өнөөгийн хөгжил цэцэглэлтийг харуулсан бүтээлүүдээр гэрэл зургийн үзэсгэлэн, цомог бэлтгэх юм.

Энэхүү хоёр орны гэрэл зурагчдын багт Монголын талаас ахмад фото сэтгүүлч Л.Санжмятав, багш, фото мастер В.Баттулга, С.Бадамханд нарын туршлагатайзурагчид,БНХАУ-ын талаас ӨМӨЗО-ны Гэрэл зургийн нийгэмлэгийн дарга Эв, “Гэрэл зураг” сэтгүүлийн эрхлэгч Баянбулаг, фото сэтгүүлч Оюундалай, Шинь Эн Чау, Ван Юу нарын уран бүтээлчид хамрагдсан юм.

Ирэх жил ӨМӨЗО-ны 70 жилийн тэгш ой тохиож байгаа бөгөөд энэхүү түүхэн тэмдэглэлт үйл явдалд зориулсан хоёр орныг сурталчлах ажлын хүрээнд уран бүтээлчдийн хамтын ажиллагааг хөгжүүлэх ажилд ийнхүү томоохон ахиц гарлаа. Хоёр орны уран бүтээлчдийн гэрэл зургийн бүтээлийн хамтарсан үзэсгэлэн ирэх наймдугаар сарын эхээр Монгол Улсаднээлтээхийхюм. Мөн энэ үеэр МГЗНХ-ныхон ӨМӨЗО-ны гэрэл зурагчдыг Монгол орны байгалийн үзэсгэлэнт газруудаар аялуулж, уламжлалт монгол ахуй, түүх дурсгалын зураг авах боломжоор хангахаар ажиллаж байна.








Улаанбаатарт:

Маргааш

Өдөр +28
Шөнө +12

Нөгөөдөр

Өдөр +29
Шөнө +15

### Өдрийн зурхай

**Аргын тооллын:**
*2016 оны 7-р сарын 1, Баасан гараг*

**Билгийн тооллын:**
*Шинийн 27. Таван шар мэнгэтэй хөх Бич өдөр.*

**Наран ургах/шингэх:**
*05:57 / 21:55*

**Үс засуулбал:**
*Өлзийтэй сайн.*



Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр цэрэг татах, дайснаа дарах хатуу үйлийг үүсгэвээс зохистой. Бурханы үйл, хувцас хийхэд сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун чих хангинавал үзэсгэлэн болох, зүүн нь бол үхэл болсныг сонсох, нохой уливал сонсголонтой үг сонсох, тагнай загатнавал гэр арвидах, бие татвал хүн ирэх, хөл татвал гомдол аюул болно. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой.

